

**"МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР" ОНӨТҮГ
АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан ундэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжик эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: 2017.12.07

Дагаж мөрдөх огноо: 2019.01.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2019. 04. 25.

1. Байгууллагын нэр	2. Нэгжийн нэр
"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГазар	Захиргаа, санхүүгийн алба
Албан тушаалын нэр: Сахиул	Албан тушаалын ангилал Зэрэглэл: ТҮ-1-5
Ажлын цаг: 1 хоногт 8 цаг	Ажлын байрны албан ёсны байршил: 2-201 тоот, Энхтайван найрамдлын ордон, 3 дугаар хороо, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот
Хөдөлмөрийн нэхцэл: Хэвийн	Онцгой нэхцэл:

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

Албан тушаалын зорилго:

"Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын Хүй долоон худагт хамаарах нийт газар нутаг, барилга байгууламжын эд хөрөнгийн аюулгүй байдал, хадгалалт хамгаалалтыг хариуцана.

Албан тушаалын зорилт:

- "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын үйл ажиллагааг хэвийн явуулах нэхцэлөөр хангах, Хүй долоон худаг дахь хариуцсан эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.
- "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын барилга байгууламжийн бүрэн бүтэн байдлыг хариуцан, хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажиллах.
- "Байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг чанд мөрдөх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага оролцооны хэлбэр
	1. Хүй долоон худгийн морь барияны газрын нийтийн эзэмшлийн зам талбайн тэмдэг, тэмдэглэгээ, автомашины зогсоолуудын алаг болон эко хавтангууд, явган хүний болон туслах тэмдэг тэмдэглэгээ, автобусны зогсоол, замын хаалтууд, хашлага, гэрэл, гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн шон, КТП, цахилгаан шить, радио үзелийн байр,	50	Туслах-Т Хариуцан гүйцэтгэх-Г Хянах-X Шийдвэрлэх-Ш

1 дүгээр зорилтын хүрээнд	<p>Сүүдрэвч, радио үзэлийн шон, хянах самбар гэх мэт хариуцсан эд хөрөнгийн бүрэн бүтэн байдалд хяналт тавих, хамгаалах</p> <p>2. Хүй долоон худгийн барилга байгууламж болон байгууллагын өмч хөрөнгийг байнгын хараа хяналттай байлгах, орох гарах хаалга, хаалтуудыг хянах</p> <p>3. А, Б талбай болон оффисын хашаан доторх объект, нийтийн бие засах газруудын бүрэн бүтэн байдлыг хариуцах</p> <p>4. Өдөр тутмын үйл ажиллагааг баримтжуулан тогтмол тэмдэглэл үйлдэж, удирдлагад танилцуулах.</p> <p>5. Өөрийн хариуцсан талбайн орчны хог хаягдлыг цэвэрлэх, эмх цэгцтэй байлгах, цэвэр цэмцгэр байдлыг хариуцах</p> <p>6. Ногоон байгууламжийн зүлэг, мод, цэгцийн мандал зэргийг хамгаалах, услах</p>		
2 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Зөрчил, дутагдлыг нэн даруй удирдлагад мэдэгдэж, гарз хохирлоос урьдчилан сэргийлэх</p> <p>2. Барилга байгууламж болон тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хяналт тавих замаар аюулгүй орчинг хангаж ажиллах</p> <p>3. Ажлын байранд хөдөлмөр хамгааллын аюулгүй байдлыг хангаж ажиллах, зориулалтын хувцас өмсөж ажиллах</p> <p>4. Засвар үйлчилгээний хүсэлт гаргаж, өмч хөрөнгийн мэдээллийг удирдлагад танилцуулах</p> <p>5. Баяр ёслолоор болон цаг үеийн шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллах</p>	30	Т
3 дугаар зорилтын хүрээнд	<p>1. Сахилга, ёс зүй, хууль тогтоомж, дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллах</p> <p>2. Удирдлагаас хариуцулсан бусад ажлын биелэлтийг тайлгах</p> <p>3. Шаардлагатай тохиолдолд сэлгэн ажиллах</p> <p>4. "Монгол наадам цогцолбор" ОНӨТҮГ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу Үндэсний их баяр наадмаар ажиллах.</p>	20	Т

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Тусгай дунд
Мэргэжил	Харгалзахгүй

Мэргэшил	Харгалзахгүй
Туршлага	Харгалзахгүй
Ур чадвар	<ul style="list-style-type: none"> - Багаар ажиллах чадвартай - Харьцааны соёлтой - Хувийн зохион байгуулалт сайтай - Бусдыг сонсох чадвартай - Нягт нямбай, эмх цэгтэй - Асуудлыг эрэмбэлэх чадвартай - Байгууллагын болон хувь хүний нууцыг хадгалах

IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалтны нэр: Газрын дарга Орлогч дарга	
Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо: -	Бусад харилцах субъект: 1. Хамтран ажиллаж буй гэрээт байгууллага болон хувь хүн

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:	Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:
Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ЫН Хууль, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн:  Б. Нанжид	Монгол наадам цогцолбор ОНӨТҮГ-ЫН Дарга  Д. Хатанбаатар (Тамга, тэмдэг) 2019 оны 04 дүгээр сарын 05.. ны өдөр <small>ATA2084 5761468</small>